



1980 оны 3 дугаар  
сарын 31 ны өдөр

99

**УЛААНБААТАР**  
**ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН**  
**ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ**  
**ЗАХИРАМЖ**

Дугаар 78

Улаанбаатар  
хот

ХОТЫН ХУДАЛДАА УДИРДАХ ГАЗРЫН  
БАРИЛГА ЗАСВАРЫН АНГИЙГ БАРИЛГА  
ЗАСВАРЫН НЭГДСЭН ТРЕСТЭД ШИЛЖҮҮЛЭХ  
ТУХАА

1. БНМАУ-ын СнЗ-ийн 1980 оны 80-р тогтоолын 1-р заалтыг үндэслэн Хотын худалдаа удирдах газрын барилга засварын ангийг ажиллаж буй орон тоо, үндсэн ба эргэлтийн хөрөнгийг нь хамтаар 1980 оны 4-р сарын 1-ний өдрөөр тасалбар болгон хотын Барилга засварын нэгдсэн трестэд шилжүүлж, аж ахуйн тооцоотой контор болгон, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээний салбарын барилга байгууламжийн засварын ажлыг эрхлэн гүйцэтгүүлэхээр өргөтгөн зохион байгуулж ажиллуулахыг БЭН трест /н.Гэндэндармаа/-д зөвшөөрсүгэй.

2. Хотын худалдаа удирдах газрын барилга засварын ангийг Барилга засварын нэгдсэн трестэд шилжүүлэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын даргад: Р.Гэндэндарам - БЭН Трестийн дарга

Орлогч дарга - Г.Хишгээ - Хотын Худалдаа удирдах газрын нэгдүгээр орлогч дарга

Гишүүдэд: Т.Хүрэлбат - Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Их барилгын хэлтсийн ахлах мэргэжилтэн

С.Намхайноров - НААҮЯ-ны хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Д.Ундорж - БЭН трестийн ерөнхий ня-бо

Ж.Гүрсэд - " - туслах үйлдвэрийн дарга

Я. Гүржав-БЭН трестийн санхүүгийн мэргэжилтэн

Ө.Дорж - Хотын худалдаа удирдах газрын  
барилга засварын ангийн дарга

Т.Наваа -- " - - " - ня-бо

3.Барилга нэг бүрийг ажлын гүйцэтгэл, зураг төсвөөр нь устгалын ба эхлэлтийн баланс хийлгэн чанартай хүлээлцүүлэх ажлыг 4-р сарын 5-ны дотор дуусгахыг комисс /н.Гэндэндаргаа/-т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АЖУУХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ДАРГА С.МОНУЖАРГАЛ

*[Handwritten signature in blue ink]*